



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 4/169

Номгон

Улсын газар зохион байгуулалтын Ерөнхий  
Төлөвлөгөөг 2021 онд хэрэгжүүлэх үйл  
ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн "Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлах тухай" 384 дүгээр тогтоолын 3.б дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг 2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Т.Хишигбаатар – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Ж.Баттөр – Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Э.Ганзориг – Байгаль орчин аялал, жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Г.Хүрэлсүх – Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Т.Ганболд – Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга

Ж.Уламбаяр – "Баянхонгор-Эрчим хүч" ЦТ ХХК-ны дарга

Б.Намуун – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Д.Алтангэрэл- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

3.Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг 2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж 03 дугаар сарын 20-ны дотор Засаг даргад танилцуулж, батлуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Т.Хишигбаатар)-д үүрэг болгосугай.

1210413

2.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, уул уурхай, нийгмийн бодлогын асуудал эрхэлсэн орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН